

## **БҮХ АРД ТҮМНИЙ САНАЛ ХУРААЛТ ЯВУУЛАХ БОЛСОН ГАДААД УЧИР ШАЛТГААН**

*Т.Төмөрхүлэг\**

Гурван гүрний Ялтын уулзалтын дүнд гарсан баримт бичигт “Гадаад Монголын статус-квог одоогийн байдлаар нь хүлээн зөвшөөрнө” гэж томъёолсон байгаа. Өнгөн талаас нь үүнийг хоёрдмол утга агуулсан гэж үзэж болохоор зүйл. Уг үйл явдлын цаашдынх нь өрнөлтөөр бодоход Зөвлөлтийн дипломатчид зориуд ингэж битүүхэн томъёолсон нь илэрхий. Юу вэ гэвэл хятадууд тэрхүү заалтаар маргах шалтаг олсон. Хятадын төлөөлөгчийн тэргүүн Сүн Зывэнь, гурван гүрний удирдагчдын хэлэлцээрт “одоогийн байдлаар нь” гэдгийг БНХАУ, ЗХУ-ын 1924 оны гэрээнд ЗСБНХУ Гадаад Монголыг Хятадын салшгүй нэг хэсэг гэж нэгэнт хүлээн зөвшөөрсөн болохоор Хятадын эзэн эрхийг хэвээр үлдээнэ гэж ойлгосон хэмээн тайлбарлаад Гадаад Монголын асуудлыг хэлэлцэхээс эхний үед сүрхий цааргалж байсан юм. Үүнд Сталин Хятадын төлөөлөгчдийн тэргүүнтэй хэлэлцэхдээ “одоогийн байдал гэдэг нь тусгаар тогтнолыг хэлж байгаа юм” гэж тулган Монголыг тусгаар улс байлгахын цаад учир холбогдлыг илэн далангүй, эрс зоримог гаргаж тавьсан. Зөвлөлтийн чухамхүү энэ байр суурьнаас шалтгаалж уг хэлэлцээ сунжирч арван удаа /6 дугаар сарын 30-наас 7 дугаар сарын 12 хүртэл 6 удаа, 8 дугаар сарын 8-наас 14 хүртэл 4 удаа/ хуралдсан юм.

Ингэхээр АНУ-ын Ерөнхийлөгч Рузвельт, Английн Ерөнхий сайд Черчилль хоёр Гадаад Монголын статус-квог одоогийн байдлаар нь хүлээн зөвшөөрнө гэсэн баримт бичигт гарын үсэг зурахдаа Ар Монголыг тусгаар тогтносон улс болгох гэсэн санаа гэж ойлгосон уу?, аль эсвэл Хятад, Зөвлөлтийн 1924 оны хэлэлцээрийг мөрдөж байна гэж бодсон уу? гэсэн асуулт аяндаа гарч ирэх учиртай.

Крымийн уулзалтын баримт бичгийн уг эхийг, тухайлбал Гадаад Монголын талаархи заалтыг Молотов авгай навтаргалсан гэсэн. АНУ, Английн удирдагч нарын зүгээс эл баримт бичгийн үг үсгийн талаар ямар нэгэн асуулт тавьсан, тайлбар шаардсан зүйл ер гараагүй, Рузвельт, Черчилль хоёр төвөг учруулалгүй гарын үсгээ зурсан гэж байгаа. Черчилль өөрийн дуртгалдаа, “..Уг асуудал Америкийн тухайд тэргүүн зэргийн ач холбогдолтой байсан болохоос биш бидний хувьд шууд

\* Т.Төмөрхүлэг - МУИС-ийн Түүхийн судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D), Онц бөгөөд бүрэн эрхт элчин

хамааралтай байгаагүй. Шийд гармагц биднийг гарын үсгээ зурна уу гэсэн. Бид ч ёсоор болгосон...” гэжээ<sup>1</sup>. Тайваний түүхч Лян Зиндуй гэдэг зохиогч бичихдээ, “1945 онд Дундад улсын үхэнц дорой байдал, Сталины атгаг санаа, Рузвельтийн гэнэн зан, Трумэний мэдлэггүй нь дайны дараах Алс Дорнодын гай гамшгийн гол хүчин зүйлс болсон...” гэсэн буй. Саяхь түүхчийн бичсэнээс үзвэл “... Дундад улс Гадаад Монголын тухайд эзэн эрхээ авч үлдэх юм бол тус орныг одоогийн байдлаар нь хүлээн зөвшөөрөхөд ямар ч асуудал гарах ёсгүй...”<sup>2</sup> хэмээн Рузвельт үзэж байлаа гэжээ. Рузвельт энэ үгийг хятадуудад хэлсэн байж болох л юм. Гэтэл 1943 оны 11 дүгээр сард Каирт болсон их гүрнүүдийн уулзалтын явцад Чан Кайши АНУ-ын Ерөнхийлөгч Рузвельтэд хандан “БНМАУ-ыг Хятадын бүрэлдэхүүнд оруулах” хүсэлт тавихад Рузвельт энэ асуудлыг ЗХУ-тай ярилцаж шийдэхгүй бол болохгүй гэсэн шалтаг гаргасан.<sup>3</sup> Ялтын бага хурлын бэлтгэл ажлын явцад Сталин /Крымийн зөвлөгөөн болохоос хэдэн сарын өмнө/ 1944 оны 10 дугаар сарын 15-нд Москвад суугаа АНУ-ын элчин сайд Харримантай уулзахдаа, Японыг дарж авах дайнд оролцох болзлынхоо нэгэнд БНМАУ-ын тусгаар тогтнолын асуудлыг багтаан ярьж урьдаас дохио сануулга өгч байсан ажээ. Сталин бээр “БНМАУ-ын статус-квог хэвээр үлдээнэ гэдэг нь Гадаад Монголыг бие даасан субъектийн хувьд байлгахыг хэлж байгаа юм”<sup>4</sup> гэж Харриманд шууд хэлж байжээ. Бас Ялтын бага хурлын үеэр буюу 1945 оны 2 дугаар сарын 8-нд Сталин Рузвельтээс “Гадаад Монголын статус-квог хэвээр байлгах асуудлыг хэрхэн үзэж байна вэ? гэж тулгах маягаар асуухад “Энэ асуудлаар Чан Кайштэй зөвлөлдөж амжаагүй, гэвч Гадаад Монголын статус-квог хэвээр үлдээх нь зүйтэй гэж үзэж байна”<sup>5</sup> хэмээсэн хариулт өгчээ.

Зөвлөлт, Хятадын хэлэлцээ эхнийхээ үе шатанд мухардалд орох шинжтэй болсон. Энэ хэлэлцээг урагшлуулахад гол тээг болсон зүйл нь Гадаад Монголын тусгаар тогтнолын асуудал байсан гэж олон судлаач шинжээчид үздэг нь аргагүй юм. Хятадын төлөөлөгчдийн тэргүүн цөхрөнгөө барахдаа, АНУ-ын элчин сайд Харриманаар уламжлуулан АНУ-ын Төрийн департаментас Америк улс Ялтын хэлэлцээрт гарын үсэг зурсан гүрний хувьд уг хэлэлцээрийн талаар, тухайлбал Гадаад Монголын тухай зөв тайлбар өгч Сталинтай цаашид хийх хэлэлцээнд дэм үзүүлэхийг гуйсан байна. Төрийн нарийн бичгийн дарга Бирнс Харриманд явуулсан илгээлтдээ: “АНУ-ын засгийн газар Монголын статус-квог хэрхэн ойлгох вэ гэх зэрэг асуудлаар Ялтын Гэрээний зүйл ангийг нарийн хэлэлцээгүй...” гээд түүний хувийн бодлоор бол

“хууль эрх зүйн үүднээс Хятад Гадаад Монголд эзэн эрхтэй байж болох боловч үнэн хэрэгтээ энэ нь хэрэгжих бололцоогүй зүйл юм”<sup>6</sup> гэсэн хариу өгчээ. Төрийн нарийн бичгийн дарга Бирнс “хувийн бодол” гэж хэлсэн боловч чухамдаа энэ нь АНУ-ын баримталсан байр суурь байсан гэж үзүүштэй. Учир нь гэвэл Ялтын бага хурлын дүнд байгуулсан хэлэлцээрийн тухайд ерөнхийлөгч Рузвельт Чан Кайшигийн зөвшөөрлийг авах үүрэг хүлээснээс ч аваад үзэхэд Америк тодорхой байр суурьгүй байсан гэхэд үнэмшилгүй. Дээр өгүүлснээр Чан Кайши ч /1943 онд/, Сталин ч /1945 онд/ Ар Монголын асуудал хөндөж ярихад Рузвельт Ерөнхийлөгч аль болохоор булзааруулах маягтай хариулт өгч байсан нь чухамдаа дипломат ов мэх байсан болов уу.

Рузвельт, Ялтын хэлэлцээ болохоос нэлээд хэдэн сарын өмнө буюу 1944 оны 7 дугаар сард дэд ерөнхийлөгч Г.Уоллесийг Улаанбаатарт илгээсэн нь Монголын талаар бодот мэдээлэл судалгаатай болох гэсэн нь мэдээж. Г.Уоллес Монгол болон ЗХУ-ын Алс Дорнод, Дундад Ази, Сибир, Хятадын зүүн хойд мужуудаар хийсэн аяллынхаа тухай Ерөнхийлөгч Рузвельтэд тусгай илтгэл бичиж өгчээ. Энэ аяллынхаа талаар Уоллес “Зөвлөлтийн нутгаар аялсан минь” хэмээх номдоо, “Дэлхий дахиныг хамарсан дайны үед Зөвлөлт-Монголын гэрээ /1936 оны хэлэлцээрийг хэлж байна/ Америкийн хамгаалалтад цайзны үүрэг гүйцэтгэжээ. Зөвлөлт, Монголын олон жилийн найрамдал нь бидний ашиг сонирхолд нийцэж байв. Зөвлөлтийн Алс Дорнодын болон Гадаад Монголын цэргийн хүчин 1945 онд /Уоллесын энэ ном 1945 оноос хойш хэвлэгдсэн/ манай талд байсан бөгөөд Манжуур дахь Японы цэргийн хүчнийг бут ниргэхүйц айлган сүрдүүлэх зэвсэг болж байв” гэжээ. Мэдээж, энэ дүгнэлт нь тухайн үед Америкийн зүгээс Алс Дорнодын талаар баримталж байсан бодлоготой нь учир холбогдолтой гэдэг нь тодорхой. Дээрхи баримт сэлтээс үзэхэд 1945 оны Крымын уулзалтад Ерөнхийлөгч Рузвельт Гадаад Монголын буюу БНМАУ-ын хувьд тодорхой ойлгогцгүй байсан гэж хөнгөн хуумгай дүгнэлт хийж хараахан болохгүй мэт. Тэр тусмаа Рузвельтийг “гэнэн” гэж нэрлэж ч таарахгүй биз. Харин ч Америкийн алс хэтийн оньч /стратегийн/ бодлогын үүднээс ЗХУ, Хятадын хооронд Монгол мэт бамбай улс орших нь АНУ-д алсдаа ашигтай гэж тооцоолж байсан ч байж болох талтай. Үүнийг би, тэр үед Гадаад Монголын талаар Америкийн удирдагчдын баримталж агсан улс төрийн байр суурийн зөвхөн нэг тал нь байсан байж болох юм гэсэн утгаар өгүүлж байгаа юм.

Зөвлөлттэй хэлэлцэхдээ АНУ-ын зүгээс дэмжлэг авах гэсэн

Хятадын найдлага ийнхүү тасарсан нь Чан Кайши болон тэр хүний хамтран зүтгэгчдийг бүр ч мухардуулсан билээ. Сталины байр суурь ч улам чангарч, хэлэлцээ явцгүй тийшээ хандах шинжтэй болсныг хятадууд нэгэнт мэдэрсэн тул Монголын асуудлаар бяцхан буулт хийх маягтай зарим нэг санал гаргасан. Үүнд Сүн Зывень дарга Гадаад Монголд Хятадын эзэн эрхийг хэвээр үлдээх, чингэхдээ, өргөн хэмжээний автономи эрх олгох, үүний дагуу Ар Монгол өөрийгөө засан тохинуулж, гадаад харилцаа, цэргийн явдлын хувьд мөн өөртөө эзэн байх эрхийг эдлэх бөгөөд дотооддоо засах эрх олсныхоо дараа гадаад харилцааны хувьд биеэ даасан зарчмыг хэрэгжүүлж болно. ЗХУ-тай ч гэрээ хэлэлцээр байгуулж болох юм гэж байжээ. Эл санал нь цаг хожих гэсэн нэгэн арга байсан нь гарцаагүй. Сталин энэ саналыг нь огоорсон.

Америкийн тэр үеийн улс төрийн зүтгэлтнүүд /Рузвельт, Хенри Уоллес/ Хятад дахь дотоодын дайн самууныг зогсоохын тулд /коммунистуудыг тогтоон барих/ давын түрүүнд Дундад улс, Зөвлөлтийн харилцааг заавал сайжруулах хэрэгтэй гэж Хятадын удирдагчдад зөвлөж байсан. Тэр үед ЗХУ Хятадын коммунист намд биш, Төв засгийн газарт /Чан Кайшигийн засгийн газар/ нь туслаж байсан бөгөөд хэдийгээр Чан Кайши эл дэмжлэгийг цаашдаа найдвартай гэж итгэдэггүй байсан ч ямар ч атугай энэ нь Москвагийн удирдагчидтай тэрсэлдэж болохгүйн нэгэн хүчин зүйл байлаа. Нөгөөтэйгүүр улаан арми Хятадыг чөлөөлөх нэрийдлээр Алс Дорнод руу нэвтрэн орохдоо Манжуур, Өвөр Монголыг тусгаарлан өөрийн дэглэмийг тогтоож ч магадгүй гэж америкчууд дотроо хардаж хятадуудыг сэрэмжлүүлж байсан, Зарим түүхч бичихдээ, Холбоотон гүрнүүд Японы цэргийн хүчийг хэтийдүүлэн үнэлж байсан гэдэг. Японы армийн хүчин чадал ямар ч байсан гэсэн Хятад дотоодынхоо зөрчил тэмцэлд сульдаад өөрийн хүчээр япончуудыг богино хугацаанд нутгаасаа хөөж гаргах цэрэг-эдийн засгийн чадамжтай байгаагүй. Энэ ч үүднээс Японтой хийж байгаа дайныг дуусгахаас өмнө ЗХУ-тай найрамдал холбоотны гэрээ байгуулах нь Хятадын удирдагчдын тухайд амин шаардлага болжээ. Чухамхүү энэ нөхцөл байдлын шахалтаар Хятад Гадаад Монголын асуудлаар Сталинд буулт хийхээс өөр аргагүйд хүрсэн юм.

Долдугаар сарын 5-нд Чан Кайши Гоминданы намын эрх баригчдыг дуудан хуралдуулж БНМАУ-ын талаархи Сталины шаардлагыг тодорхой гурван болзолтойгоор хүлээн авахаар шийдсэн. /Нэгд, Манжуурын талаархи Хятадын эзэн эрхийг бусниулахгүй, Хятадын нэгдмэл байдлыг бугархахгүй, үүнд Порт-Артурыг хамтран

эээмших, Даляныг 20 жилийн хугацаагаар нээлттэй боомт болгон зарлах, Дорнод Хятадын болон Өмнөд Манжуурын төмөр замыг хоёр орон хамтран ашиглаж ашгаа тэнцүү хувааж авах, хоёрт, Шиньжааны асуудлаар ЗХУ Хятадтай хамтран ажиллаж тэрхүү хязгаар нутагт болж буй үймээн самууныг арилгах, гуравт, Хятадын коммунистууд өөрийн захиргаа, армитай болж буй тул ЗХУ хойшид ч Төв засгийн газрыг сэтгэл санааны хувьд дэмжин эд агуурсын тусламж үзүүлж байх/.

Чан Кайшигийн Засгийн газрын Гадаад Яамны сайд Ван Шизегийн Монголын талаар Молотовт илгээсэн ноот бичгийг хятад хэлнээс үгчилсэн маягаар орчуулсан нь ийн буюу: “Ар Монголын ард түмэн тусгаар тогтнох хүслээ удаа дараа илэрхийлж байсан, Хятадын засгийн газар Японы дайн дууссаны дараа Гадаад Монголын ард иргэд бүх нийтийн санал хураалтаар энэ хүсэлтээ илэрхийлэх юм бол Хятадын засгийн газар Ар Монголын тусгаар тогтнохыг зөвшөөрч одоогийн хилээр хил хязгаарыг нь зааглан тогтоохоор мэдэгдсэн билээ”<sup>7</sup> Хятад ЗХУ-д ийнхүү буулт хийсэн нь ХХ зууны Монголын гадаад харилцааны түүхэнд төдийгүй тусгай нэгэн улсын хувьд тус орны цаашдын дэвжин өөдлөх замд томоохон эргэлт болсон хэрэг гэж үзүүштэй. Гэхдээ Хятад улс Гадаад Монголд ард иргэдийн санал хураалт заавал явуулах нөхцөл тавилгүйгээр тусгаар тогтнолыг нь хүлээн зөвшөөрлөө гээд Зөвлөлттэй байгуулсан Гэрээндээ тунхагласнаар хязгаарлаж болох байсан уу?, эсвэл ийм улгаар ноот бичиг ч солилцож болох байсан уу? гэвэл болох байсан. Ямар учиртай вэ гэвэл Сталинтай БНМАУ-ын талаар хэлэлцсэн Хятадын төлөөлөгчид Ар Монголыг алдсан манай аль ч засгийн газар нь ард түмэндээ нүүргүй болно, тогтож ч чадахгүй гэж их учирлаж байсан. Тэгэхээр түүнээс гарах ганц гарц нь гэвэл Монголд ард нийтийн санал хураалт явуулах арга байжээ. Тиймээс ч Сун Зывэнь манайд болсон санал хураалтыг Гадаад Монгол яагаад тусгаарласныг хятадын ард олонд ухааруулах “хэлбэрийн төдий асуудал” гэж тайлбарлаж байсан юм. Хэрэв энэ нь Хятадад “хэлбэрийн асуудал” байсан бол Монголд аз завшааны хэрэг болсон юм. Яагаад тэр вэ гэвэл, аливаа нэг улсын бие даан оршин тогтнохын нэг нөхцөл нь тэр ард түмний хүсэл зоригоос хамаарах учиртай гэдэг орчин үеийн олон улсын эрх зүйн баримтлалыг Улс түмний тусгаар тогтнон орших эрхийн тухай НҮБ-ын тунхаглал гарахаас олон жилийн өмнө манай Монголын ард түмэн үлгэр жишээгээр харуулсан юм.

**ИШЛЭЛ, ЗҮҮЛТ**

1. Memoirs of Winston Churchill, Boston, 1963, vol.III, p.390
2. Лян Зиндүй. “Дундад, Зөвлөлтийн Найрамдал холбоотны тухай 1945 оны Гэрээний талаархи хэлэлцээний далд учир” өгүүлэл, Л.Жамсраны орчуулга. “Дорно дахины судлалын асуудал”, 1989, 2(21), 20 дахь тал
3. Foreign Relations of the United States, Diplomatic Papers. The Conferences at Cairo and Teheran. 1943, Wash., 1961, pp. 325-326, 367
4. Ц.Батбаяр. “Ялгын бага хурал ба БНМАУ-ын статус-кво-гийн асуудал” өгүүлэл. “Дорно, Өрнө” сэтгүүл, 1997, №1,2, 77 дахь тал
5. John W.Garver. Chinese-Soviet Relations, 1937-1945: The Diplomaty of Chinese Nationalism New York, Oxford, 1988, p. 197-198
6. American Diplomatic Documents, vol. VIII, Washington, 1945, p.202
7. Хятад, Оросын харилцааны түүхэн дэх Монгол Улс (XX зуун). Баримт бичгийн эмхэтгэл. Г.Гунгаагийн орчуулга, Улаанбаатар, 1995, 79 дэх тал